

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурлын огноо: 2026 оны 4 сарын 28-ны өдөр

Хурлын байршил: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Бага тойруу 1, Амарын гудамж, Сентрал Тауэр, 17 давхар, Криптос хурлын танхим, Ард Алш Хурал эхэлсэн цаг: 11 цаг 00 минут

Хурлын дарга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга О.Одбаяр

Хурлын ирц: Нийт саналын эрхтэй хувьцааны тоо 25,000,000 ширхэг, хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй хувьцааны тоо 19,753,649 ширхэг буюу 79.1 хувь

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан танилцуулах;
2. 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт танилцуулах;
3. 2025 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
4. 2026 оны ТУЗ-ийн төсөв танилцуулах;
5. Ногдол ашиг хуваарилах талаарх тухай
6. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулж батлуулах тухай;
7. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай;
8. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай;
9. Хувьцаа халааслах тухай

Тэмдэглэл:

ТУЗ-ийн дарга О.Одбаяр: Та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе. Хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигчдэдээ бизнесийн өндөр амжилт хүсье. 2025 онд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 6.8 хувиар өсөж, 89.9 их наяд төгрөгт хүрсэн байна. Энэхүү өсөлтөд эдийн засгийн бүх салбарууд хувь нэмрээ оруулсан бөгөөд даатгалын салбар ч мөн өсөлттэй үзүүлэлттэй байлаа. Ард Даатгал ХК нь 2025 онд цахим даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны процесс болон харилцагчийн үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлд голлон ажилласан. Мөн олон улсад түгээмэл хэрэглэгддэг тайлагналын гурван төрлийн стандарт аргачлалыг нэгэн зэрэг нэвтрүүлэн хэрэгжүүлж буй Монгол Улсын анхдагч даатгалын компани болсныг дуулгахад таатай байна. Эцэст нь, хувьцаа эзэмшигчид, харилцагчид болон хамтран ажиллагч түншүүддээ гүн талархал илэрхийлье. Даатгалын салбар нь Монгол Улсын ирээдүйтэй салбаруудын нэг бөгөөд энэ салбарт хөрөнгө оруулж буй та бүхнийг том ирээдүй хүлээж байна гэдэгт итгэлтэй байна. Ийнхүү ХЭХ нээснийг мэдэгдье.

Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл: Сайн байцгаана уу? Өнөөдөр буюу 2026 оны 4 сарын 28-ны 11:00 цагт Ард Даатгал ХК-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарласан байгаа. Та бүхэнд түрүүн хэлсэнчлэн 11:00-11:05 хүртэл ирцийн бүртгэлийг үүдний хэсэг болон Ард Алш-р бүртгэсэн. Өнөөдрийн хуралд Компанийн тухай хуулийн 67-р зүйлд заасанчлан Тооллогын Комиссын эрх үүргийг хэрэгжүүлэхээр

тооллогын комиссын даргаар миний бие Ө. Бямбагэрэл, тооллогын комиссын гишүүдээр Ч.Даваацэрэн, Эрдэнэбилэг нар тус тус ажиллаж байна. Өнөөдрийн хурлын дэгийн дагуу хурлын ирцийн баталгаажуулалтыг та бүхэнд танилцуулъя. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2 дахь заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтын дагуу 2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан Тооллогын комиссын тогтоолоор хурлын ирцийг баталгаажуулсан болно. Ард Даатгал ХК нь нийт 25 сая ширхэг энгийн хувьцаа гаргасан бөгөөд өнөөдрийн хуралд саналын эрх бүхий 19,753,649 ширхэг хувьцаа, өөрөөр хэлбэл 79.1 хувийн ирцтэйгээр хувьцаа эзэмшигчид оролцож байна. Иймд Компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу хурал хүчин төгөлдөр болох нөхцөл хангагдсан болохыг албан ёсоор мэдэгдэж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ард Даатгал ХК-н ЭХУГ-н захирал Г.Баярбат: Хурлын дэгийн дагуу компанийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг миний бие танилцуулж байна. Юуны өмнө компанийнхаа бүтцийг товч танилцуулъя. Манай компанийн шийдвэр гаргах дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд үүнээс сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн үйл ажиллагаанд бодлогын түвшинд хяналт тавин ажилладаг. ТУЗ-ийн дэргэд засаглал, нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хороо, санхүү, эрсдэл, хөрөнгө оруулалтын хороо болон аудитын хороо гэсэн дөрвөн хороо ажиллаж, гишүүд нь эдгээрт хуваарилагдан зөвлөмж, шийдвэр боловсруулж ТУЗ-д танилцуулдаг. Нөгөө талаас гүйцэтгэх удирдлагын түвшинд гүйцэтгэх захирлын дэргэд гүйцэтгэх удирдлагын хороо, эрсдэлийн хороо, ёс зүйн хороо, мөн мэдээллийн аюулгүй байдал, цахим хөгжлийн хороо тус тус ажиллаж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байна. Компанийн үндсэн бүтэц нь даатгалын газар, эрсдэл хариуцсан удирдлагын газар, нөхөн төлбөрийн газар, мөн үйл ажиллагаа болон санхүүгийн нэгжүүдээс бүрдэн ажиллаж байна. 2025 оны хувьд манай компанийн үйл ажиллагаанд хэд хэдэн онцлох үйл явдал тохиосон. Бид ISO 9001 болон ISO 27001 стандартуудыг хослуулсан нэгдсэн менежментийн тогтолцоог амжилттай нэвтрүүлж, 2024–2025 онуудад Nexia аудитын байгууллагаар баталгаажуулалт хийлгэн эерэг дүгнэлт авсан. Мөн баталгааны даатгалын чиглэлд идэвхтэй ажилласны үр дүнд 2025 онд 276 гэрээ байгуулж, 27 тэрбум төгрөгийн баталгаа гаргасан байна.

Харилцагчийн үйлчилгээний чиглэлд бид өөрсдийн төвийг бие даан удирдан зохион байгуулж эхэлснээр нөхөн төлбөрийн процессыг цахимжуулж, үйлчилгээг илүү хурдан, хялбар, уян хатан болгох бодит ахиц гаргасан. Үүний зэрэгцээ харилцагчдад чиглэсэн урамшууллын бодлогод шинэчлэл хийж, даатгалын урамшууллыг Ард койноор олгодог тогтолцоог дүрэмдээ тусган хэрэгжүүлж эхэлсэн. Өнгөрсөн хугацаанд нийт борлуулалтын 5 хувьд дүйцэх, тухайн үеийн ханшаар 600 сая төгрөгийн урамшууллыг олгосон бөгөөд энэхүү хөтөлбөр үргэлжлэн хэрэгжиж байна.

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчдийн хурал хоёр удаа зохион байгуулагдаж, ээлжит бус хурлаар компанийн дүрмийн санг нэмэгдүүлэх шийдвэр гарсан бөгөөд уг ажил хэрэгжилтийн дуусах шатандаа явж байна. Мөн “Хялбар даатгал” үйлчилгээг өргөжүүлж, тээврийн хэрэгслийн даатгалыг шинээр нэвтрүүлсэн.

Санхүүгийн үзүүлэлтүүдийн тухайд компанийн нийт хөрөнгө 57 тэрбум төгрөгт хүрч, үүнээс 22 тэрбум төгрөг нь эздийн өмч, 23 тэрбум төгрөг нь нөөц сан байна. Нийт хураамжийн орлого 40 тэрбум төгрөгт хүрч, нөхөн төлбөрт 20 тэрбум төгрөгийг олгож, тайлант онд 3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан үзүүлэлттэй байна. Нийт хөрөнгийн 37 орчим тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын багц эзэлж байгаа бөгөөд орлого өмнөх оноос 11 хувиар буурсан хэдий ч цэвэр ашиг 27 хувиар өссөн байна. Хөрөнгө оруулалтын багцын бүтэц нь компанийн ашгийг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй бөгөөд үүний 73 хувь буюу 27 тэрбум төгрөг нь тогтмол өгөөжтэй хөрөнгө оруулалтад, 10 хувь буюу 3.7 тэрбум төгрөг нь хувьцаанд, үлдсэн хэсэг нь альтернатив болон бусад хөрөнгө оруулалтад байршуулсан байна.

Мөн даатгалын салбарт ашиглагддаг гол үзүүлэлтүүд болох хохирлын харьцаа, зардлын харьцаа, хосолсон харьцаагаар компанийн үйл ажиллагааг үнэлдэг бөгөөд хосолсон харьцаа нь үндсэн үйл ажиллагаанаасаа ашигтай ажиллаж байгаа эсэхийг илэрхийлдэг чухал үзүүлэлт юм. Хувьцааны арилжааны хувьд манай компанийн нэгж хувьцааны үнэ 601.6–760 төгрөгийн хооронд хэлбэлзэж, нийт 3.7 сая ширхэг хувьцаа 2.5 тэрбум төгрөгийн үнийн дүнгээр арилжаалагдсан. Ингэснээр компанийн зах зээлийн үнэлгээ 18.2 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд хувьцаа эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт гараагүй, бага хэмжээний шилжилтүүд хийгдсэн байна. Ингээд 2025 оны санхүүгийн тайланд аудит хийсэн Nexia Global Mongolia Audit ХХК-ийн аудитын дүгнэлтийг танилцуулахаар тус компанийн аудитын менежер Э.Батсайхан таныг урьж байна.

Нексия Глобал Монголиа Аудит ХХК-н аудитын менежер Э.Батсайхан: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Нексия Глобал Монголиа Аудит ХХК-ийн аудитын менежер Э.Батсайхан байна. Манай байгууллага Ард Даатгал ХК-ийн санхүүгийн тайланд хоёр дахь жилдээ аудит хийж ажиллалаа.

Энэ жилийн аудитын ажлын хүрээнд бид 2025 оны 10 дугаар сард завсрын аудитыг эхлүүлж, 12 дугаар сард дуусгасан. Үүний дараа 2026 оны 2 дугаар сард жилийн эцсийн аудитыг эхлүүлж, 3 дугаар сарын 31-ний өдөр бүрэн дуусгасан болно.

Аудитын ажлын үндсэн зорилго нь компанийн санхүүгийн тайлангууд Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох дүрэм журам, заавар аргачлал болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхэд хараат бус дүгнэлт өгөхөд оршдог. Мөн үүний зэрэгцээ нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэхийг зорин ажилласан.

Аудитын явцад бид эхлээд үйлчлүүлэгчийн үйл ажиллагааны онцлог нөхцөл байдалтай танилцаж, санхүүгийн хэлтэс болон бүртгэлийн зохион байгуулалт, удирдлагын бүтэц, дотоод хяналтын тогтолцоо, түүнчлэн томоохон харилцагчид болон гэрээ хэлцлийн хэрэгжилтийг судалж үнэлсэн.

Үүний дараа аудитын чухал асуудлуудыг тодорхойлж, холбогдох аргачлалуудыг боловсруулан хэрэгжүүлсэн. Тухайлбал, санхүүгийн тайлан дахь хөрөнгийн үлдэгдлийг хэсэгчлэн биетээр шалгах, орлого, зардал болон эх үүсвэрийн дансны гүйлгээг түүвэрлэн

шалгах, асууж тодруулах, тулган баталгаажуулах, давтан гүйцэтгэх зэрэг аудитын горимуудыг ашиглан нотлох баримтыг бүрдүүлсэн.

Мөн аудитын явцад эрсдэлийн хүчин зүйлүүд болон материаллаг байдлыг үнэлж, аудитын ажлын цар хүрээ, гүнзгийрлийг тодорхойлсон.

Эдгээр ажлын үр дүнд бидний гаргасан дүгнэлтээр, 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй, Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна гэж үзсэн.

Бид аудитын ажлыг гүйцэтгэхдээ аудитын олон улсын стандартыг мөрдөж, Нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийг чанд сахин, хараат бус байдлаа бүрэн хадгалж ажилласан болно.

Манай аудит хийж баталгаажуулсан санхүүгийн тайлан нь СТОУС 17 стандартын дагуу бэлтгэгдсэн бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдлын тайлан, тухайн хугацааны дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн бодлогын тайлбар болон бусад тодруулгуудыг хамарч байна. Тайлангийн гол үзүүлэлтүүдээс дурдвал: нийт хөрөнгө 53.6 тэрбум төгрөг, нийт өр төлбөр 30.4 тэрбум төгрөг, нийт өөрийн хөрөнгө 23.1 тэрбум төгрөг байна. Даатгалын үйл ажиллагааны үр дүн 12.5 тэрбум төгрөг, цэвэр хөрөнгө оруулалтын орлого 3.9 тэрбум төгрөг, татварын өмнөх ашиг 3.6 тэрбум төгрөгийн үзүүлэлттэй гарсан байна.

Ингээд бидний дүгнэлтээр дээрх санхүүгийн тайлангууд нь компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүх чухал талаараа үнэн зөв илэрхийлсэн болохыг мэдэгдэж байна.

ТУЗ-ийн дарга О.Одбаяр: За одоо та бүхэнд Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг танилцуулъя. ТУЗ нь 6 ердийн гишүүн, 3 хараат бус гишүүнээс бүрдсэн нийт 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Тайлант хугацаанд ТУЗ нийт 7 удаагийн ээлжит болон ээлжит бус хурал, мөн 1 удаагийн эчнээ хурлыг зохион байгуулж, нийт 8 удаа хуралдан 25 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. ТУЗ-өөс гаргасан онцлох шийдвэрүүдээс дурдвал ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлуудыг зарлан хуралдуулах, 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайланг дүгнэж ТУЗ-ийн дүгнэлтийг батлах, гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны үнэлгээг батлах, мөн ТУЗ-ийн дарга болон хороодын бүрэлдэхүүнийг томилох зэрэг чухал шийдвэрүүдийг гаргасан. Үүнээс гадна бүтээгдэхүүн боловсруулах журам болон давхар даатгалын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх шийдвэрүүдийг гаргасан байна.

Одоо ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг товч танилцуулъя. Засаглал, нэр дэвшүүлэх хороо нь Г.Хонгорзул, Б.Болорчимэг, Г.Уянга нарын бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж, тайлант хугацаанд 3 удаагийн ээлжит хурал зохион байгуулж, нийт 12 асуудлыг хэлэлцсэн. Үүнд ТУЗ-ийн гишүүдийн болон гүйцэтгэх захирлын үнэлгээ, ТУЗ-

ийн хороодын дахин хуваарилалт, компанийн засаглалын кодекс зэрэг гол асуудлууд багтсан. Цалин урамшууллын хороо нь Б.Болорчимэг, Г.Хонгорзул, Г.Цогбадрах нарын бүрэлдэхүүнтэйгээр 1 удаагийн ээлжит хурлыг зохион байгуулж, 5 асуудлыг хэлэлцсэн. Үүнд цалин, урамшууллын журам болон компанийн цалингийн төсөвтэй холбоотой асуудлууд орсон. Аудитын хороо нь Н.Хосбаяр, Б.Болорчимэг, Г.Уянга нарын бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж, нийт 5 удаагийн ээлжит хурлаар 18 асуудлыг хэлэлцсэн. Голчлон нөхөн төлбөрийн аудит, хөндлөнгийн аудитын дүгнэлт, давхар даатгал, борлуулалтын гэрээ, гэрээний бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа болон орон нутгийн салбаруудад хийсэн аудитын тайлангуудыг авч хэлэлцсэн байна. Санхүү, эрсдэл, хөрөнгө оруулалтын хороо нь Б.Золбоо, С.Оргил, Н.Эрдэнэтулга нарын бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж, тайлант хугацаанд 5 удаагийн ээлжит хурлыг зохион байгуулж, нийт 22 асуудлыг хэлэлцсэн. Үүнд улирлын санхүү болон үйл ажиллагааны тайлангууд, гадаад төлбөр тооцоо, шүүхийн маргаантай асуудлууд, эрсдэлийн тайлан, компанийн төсөв, төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын болон давхар даатгалын төлөвлөгөөнүүд багтсан. Ингэснээр ТУЗ болон түүний дэргэдэх хороод нь компанийн засаглал, хяналт, стратегийн удирдлагыг ханган ажилласан байна.

Одоо та бүхэнд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийг танилцуулъя.

ТУЗ-ийн зардлын хувьд 2025 онд нийт 250 сая төгрөг байсан бол 2026 онд 286 сая төгрөг байхаар төлөвлөсөн нь нийтдээ 14.5 хувийн өсөлттэй байна. Үүнийг задалж харвал, цалингийн зардал 181 сая төгрөгөөс 185 сая төгрөг болж, 2 орчим хувиар өссөн. Үүнд ТУЗ-ийн дарга, хороодын дарга, гишүүд болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргын урамшууллын тогтолцоог тусгасан байгаа. Харин сургалт болон хурал зохион байгуулах зардлын хувьд 10 сая төгрөгөөс 30 сая төгрөг болж, 3 дахин өссөн төлөвлөгөөтэй байна. Энэ нь ТУЗ-ийн гишүүдийн чадавхыг нэмэгдүүлэх, сургалт, хөгжлийн үйл ажиллагааг илүү идэвхжүүлэхтэй холбоотой. Мөн урамшууллын зардал 59 сая төгрөгөөс 72 сая төгрөг болж, 22.2 хувиар өсөхөөр төлөвлөгдсөн бөгөөд энэ нь ТУЗ-ийн гишүүдийн эрүүл мэндийн даатгалын зардал багтаж байгааг онцлон дурдъя. Ингэснээр 2026 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлыг илүү үр ашигтай, бодлогын түвшинд дэмжсэн байдлаар төлөвлөсөн болно.

Ард Даатгал ХК-н ЭХУГ-н захирал Г.Баярбат: Одоо ногдол ашиг хуваарилалтын талаар товч танилцуулъя. Өнгөрсөн онд буюу 2024 оны үйл ажиллагааны үр дүнгээр бид ногдол ашиг олгохгүй байх шийдвэрийг гаргасан. Харин 2026 оны 2 дугаар сарын 2-ны өдөр болсон ТУЗ-ийн хурлаар 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах шийдвэрийг баталсан. Тус шийдвэрийн дагуу 2025 оны цэвэр ашгаас нийт 1 тэрбум төгрөгийг мөнгөн хэлбэрээр хуваарилж, нэгж хувьцаанд 40 төгрөгийн ногдол ашиг олгохоор тогтсон. Уг шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй гэрээ байгуулж, хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансаар дамжуулан ногдол ашгийг бүрэн олгож дууссан. Ингээд дараагийн асуудал болох 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулахаар ТУЗ-ийн дарга О.Одбаяр таныг урьж байна.

ТУЗ-ийн дарга О.Одбаяр: 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлын шийдвэрийн дагуу компанийн 2025 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг танилцуулж байна. Компанийн тухай хуулийн холбогдох заалтууд болон ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн, Нексиа Глобал Монголиа Аудит ХХК-аас Ард Даатгал компанийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Төлөөлөн удирдах зөвлөл хүлээн зөвшөөрсөн бөгөөд компанийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг хангалттай, бодитой гэж дүгнэсэн болно.

Ард Даатгал ХК-н ЭХУГ-н захирал Г.Баярбат: Дараагийн асуудал бол ТУЗ-ийн гишүүн сонгох асуудал байна. ТУЗ-ийн гишүүн Золбоо маань өөрийн хүсэлтээр ТУЗ-ийн бүрэлдэхүүнээс гарах өргөдлөө өгсөн байгаа учраас түүний оронд шинэ гишүүн сонгох шаардлага үүсээд байна. Иймд өнөөдрийн хурлаар энэ асуудлаар сонгууль явагдана. Одоогоор та бүхэнд нэр дэвшигчдийн дэлгэрэнгүй анкет мэдээллийг дэлгэцээр танилцуулж байна. Шинээр нэр дэвшиж байгаа хүн нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн аудит эрхэлсэн захирлаар ажилладаг, мэргэшсэн нягтлан бодогч мэргэжилтэй эрхэм байгаа. Ингээд энэ бүрэлдэхүүнээр ТУЗ-ийн гишүүний сонгууль явагдаж байгаа тул та бүхэн саналаа өгнө үү.

Дараагийн асуудал бол компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудал байна. Энэ нь толгой компанийн хүрээнд хийгдэж буй rebranding-тэй холбоотой асуудал юм. Тодруулбал Ард Даатгал ХК-ийн дүрмийн 1.4 дэх заалтад өөрчлөлт оруулахаар болж байна. Одоогийн заалтаар компани “Хүчтэй. Хамтдаа.” гэсэн уриа үгтэй, мөн компанийн бэлгэдэл тэмдэг нь ARD гэсэн гурван үсгээс бүрдсэн улаан өнгийн логотой бөгөөд хажууд нь “Даатгал since 1994” гэж бичигдсэн байдаг. Үүнийг өөрчилж, цаашид компани “Хүчтэй. Хамтдаа.” гэсэн уриа үгтэй хэвээр байх боловч бэлгэдэл тэмдэг нь “Ard” гэсэн гурван үсгээс бүрдсэн хар болон цагаан өнгийн логотой болж, хажууд нь “Даатгал ХК” гэж бичигдсэн байхаар шинэчлэгдэж байгаа юм.

Дараагийн асуудал бол хувьцаа халааслах буюу хувьцаа эргүүлэн худалдаж авах тухай асуудал байна. Та бүхэнд өмнө нь компанийн хувьцааны арилжааны нөхцөл байдлын талаар танилцуулсан. Манай компанийн хувьцаа 2025 оны байдлаар 600–760 төгрөгийн хооронд арилжаалагдаж байна. 2018 онд IPO хийснээс хойш хувьцааны ханш хамгийн өндөрдөө 2021 онд 1800 төгрөгт хүрч байсан бөгөөд үүнээс хойш аажмаар буурсаар одоогийн түвшинд хүрээд байна. 2018 онд бид анх хувьцаагаа зах зээлд гаргах үед мэргэжлийн үнэлгээний болон хууль зүйн байгууллагуудаар үнэлгээ хийлгүүлж байсан. Тухайн үед нэгж хувьцааны бодит үнэлгээ 1250 төгрөг гэж гарсан ч ТУЗ-ийн шийдвэрээр илүү олон хөрөнгө оруулагчдад боломж олгох зорилгоор 40 хувийн хямдрал үзүүлж, 700 төгрөгөөр IPO-г хийж байсан. Гэвч өнөөдөр Монголын хөрөнгийн бирж дээрх арилжааны идэвх бидний хүлээлтэд хүрэхгүй байгаа бөгөөд энэ нь зах зээлийн нийт нөхцөл байдал болон хөрвөх чадварын сул байдлаас шалтгаалж байна. Олон улсын зах зээл дээр хувьцааны үнэ нь компанийн хөрөнгө, ашигт ажиллагаа, ногдол ашиг болон ирээдүйн үнэ цэнээс хамаарч тогтдог бол манай зах зээлд харьцангуй цөөн оролцогчдын арилжаанд тулгуурлан үнэ тогтох хандлага ажиглагдаж байна. Иймээс бид жижиг

хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, ханшийг тогтворжуулах, мөн компанийн үнэ цэнийг дэмжих зорилгоор хувьцаа эргүүлэн худалдаж авах хөтөлбөрийг санал болгож байна. Энэхүү хөтөлбөр нь компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг бууруулах зорилгогүй бөгөөд зөвхөн зах зээлийн идэвхийг дэмжих, жижиг хувьцаа эзэмшигчдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн юм. Хөтөлбөрийн хүрээнд нийт 3,750,000 хүртэл ширхэг буюу нийт хувьцааны 15 хүртэл хувийг эргүүлэн худалдан авах, нэгж хувьцааны үнийг 800 төгрөг хүртэл байхаар тогтоох, 12 сарын хугацаанд хэрэгжүүлэх, мөн нийт дүнг 3 тэрбум төгрөг хүртэл байхаар санал болгож байна. За одоо үүгээр манай хэлэлцэх асуудлууд дуусаж байна.

Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл: Та бүхэнд тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулъя.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дахь хэсгийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон саналын хуудсаар урьдчилан ирүүлсэн саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай санал хураалтад 19,753,649 ширхэг буюу 79 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:
 - 1.1. Зөвшөөрсөн 19,732,451 ширхэг буюу 99.8%;
 - 1.2.Татгалзсан болон Түдгэлзсэн 0 ширхэг буюу 0.00% байх тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.
2. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийг сонгох тухай санал хураалтанд 19,753,649 ширхэг энгийн хувьцаа буюу 79 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Саналын тоо	Хувь
--	--	-------------	------

Ердийн гишүүд

1	О.Одбаяр	19,349,944	97.96%
2	Г.Уянга	19,330,759	97.86%
3	Г.Цогбадрах	19,393,358	98.18%
4	Н.Эрдэнтулга	19,464,477	98.54%
5	С.Оргил	19,185,515	97.12%
6	М.Мөнх-Эрдэнэ	19,176,893	97.08%

	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Саналын тоо	Хувь
--	--	-------------	------

Хараат бус гишүүд

1	Б.Болорчимэг	19,253,055	97.47%
2	Г.Хонгорзул	19,214,525	97.27%
3	Н.Хосбаяр	19,193,709	97.17%

3. Хурлаар хэлэлцсэн Компанийн Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 19,753,649 ширхэг

буюу 79 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос 19,741,292 ширхэгийн хувьцаа эзэмшигчид санал өгсөн ба үүнээс:

3.1. Зөвшөөрсөн 19,741,292 ширхэг буюу 99.94%;

3.2.Татгалзсан 0 ширхэг буюу 0.00%;

3.3.Түдгэлзсэн 0 ширхэг буюу 0.00% байх тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

4. Хурлаар хэлэлцсэн хувьцаа халааслах тухай асуудалд хуралдаанд оролцсон саналын эрхтэй нийт 19,753,649 ширхэг буюу 79 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос 19,408,211 ширхэгийн хувьцаа эзэмшигчид санал өгсөн ба үүнээс:

4.1. Зөвшөөрсөн 19,408,211 ширхэг буюу 98.25%;

4.2.Татгалзсан 0 ширхэг буюу 0.00%;

4.3.Түдгэлзсэн 0 ширхэг буюу 0.00% байх тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй

Тооллогын комиссын тогтоолыг танилцуулж дууслаа. Баярлалаа.

ТУЗ-ийн дарга О.Одбаяр: Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл танд баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалт амжилттай явж дүнгээ танилцууллаа. За одоо хурлаас гарсан шийдвэрийг та бүхэнд танилцуулъя.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ №01/26

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 болон 2026 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын №2 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хавсралтаар баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ №02/26

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 2026 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын №3,4 тоот тогтоолуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр О.Одбаяр, Г.Уянга, М.Мөнх-Эрдэнэ, Г.Цогбадрах, С.Оргил, Н.Эрдэнэтулга нарыг, хараат бус гишүүнээр Б.Болорчимэг, Т.Хонгорзул, Н.Хосбаяр нарыг тус тус сонгохыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн мэдээллийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлж, зохих зөвшөөрлийг авч ажиллахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Г.Баярбат)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ №03/26

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дахь хэсэг, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6.1 дэх хэсэг болон

2026 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын №5 тоот тогтоолуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн дүрмийн 1.4-д “Компани “Хүчтэй.Хамтдаа.” гэсэн уриа үгтэй байх бөгөөд компанийн бэлгэдэл тэмдэг нь ARD гэсэн гурван үсгээс бүрдсэн улаан өнгөтэй байх ба хажууд нь Даатгал since 1994 гэж бичсэн байна” гэж заасныг “Компани “Хүчтэй.Хамтдаа.” гэсэн уриа үгтэй байх бөгөөд компанийн бэлгэдэл тэмдэг нь Ard гэсэн гурван үсгээс бүрдсэн хар болон цагаан өнгөтэй байх ба хажууд нь Даатгал ХК гэж бичсэн байна” гэж өөрчилсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж холбогдох бүртгэл, зөвшөөрөл авах, зохион байгуулах, Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнах үйл ажиллагааг хийхийг Гүйцэтгэх захирал (Н.Эрдэнэтулга)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ №04/26

Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.7 дахь хэсэг болон 2026 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын №6 тоот тогтоолуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Даатгал ХК-ийн гаргасан энгийн хувьцааны 15 хувь буюу 3,750,000 ширхэг хүртэл хувьцааг эргүүлэн худалдан авч дараах нөхцөлтэйгээр халааслахаар шийдвэрлэсүгэй.

Эргүүлэн худалдаж авах тоо	3,750,000 ширхэг хүртэл (15 хувь хүртэл)
Эргүүлэн худалдаж авах нэгж хувьцааны үнэ	800 төгрөг хүртэл
Эргүүлэн худалдаж авах хугацаа	12 сар
Эргүүлэн худалдаж авах нийт дүн	3,000,000,000 тэрбум төгрөг хүртэл

2. Хувьцаа эргүүлэн худалдан авч халааслах хөтөлбөрийг Хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж хувьцаа эргүүлэн худалдаж авах ажлыг гүйцэтгэх, зохицуулагч байгууллагаас зохих зөвшөөрөл авах, харилцах зэрэг ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Н.Эрдэнэтулга)-д даалгасугай.

Ийнхүү хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр тогтоолыг баталсныг мэдэгдье. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг баталснаар амжилттай өндөрлөлөө. Хурлаа амжилттай зохион байгуулсан Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн гишүүд, удирдлагын багт талархлаа илэрхийлье. Хувьцаа эзэмшигчиддээ баярлалаа. Хурлыг хаасныг албан ёсоор мэдэгдэж байна.

ХУРЛЫН ДАРГА



О.ОДБАЯР

